ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ

2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Дугаар А/175, А/144 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 72.1.1 дэх заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1, 28.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 25 дугаар тэмдэглэлийн XIII.10, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын 2023 онд Хамтран ажиллах гэрээний 2.1.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ/ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор дүүргүүдийн цахим засаглалын бэлэн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, шаардагдах санхүүжилт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт зэргийг агуулсан "Цахим Дүүрэг" бодлогын зөвлөмж боловсруулах Ажлын хэсгийг нэгдүгээр, Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2."Цахим дүүрэг" бодлогын зөвлөмжийн боловсруулалтад бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Б.Ганбат, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, бодлогын зөвлөмжийг боловсруулан 2023 оны 3 дугаар улиралд багтаан Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж холбогдох шийдвэр гаргуулахыг Ажлын хэсэг-т, шаардлагатай судалгаа, тайлан, мэдээ, мэдээлэл, техник хэрэгсэл, хүний нөөцөөр хангаж ажиллахыг Дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД

Н.УЧРАЛ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

Цахим хөгжил, харилцаа холбооны сайд,
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар
хотын захирагч нарын 2023 оны ... дугаар
сарын ...-ны өдрийн ... дугаар хамтарсан тушаал,
захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	Б.Даваанням	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга
Гишүүд	Б.Ганбат	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх
	Б.Билэгдэмбэрэл	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
	Б.Бат-Өлзий	Нийслэлийн Бизнес инновац, хөгжлийн газрын дарга
	Б.Амартүвшин	Нийслэлийн Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	П.Эрхэмбулган	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга
	Г.Баярсайхан	Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга
	Б.Мягмарнаран	“И-Монгол академи” УТҮГ-ийн Захирал
	Ө.Гантулга	“Үндэсний Дата төв” УТҮГ-ийн Захиргаа, удирдлагын газрын дарга
	Б.Бямбасүрэн	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалтын тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Д.Оюунбат	Нийслэлийн Онцгой Комиссын нарийн бичгийн дарга
	Н.Энхболд	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
	П.Баянбаатар	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
	Б.Бат-Өлзий	Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга

	Д.Төмөрбаатар	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
	С.Энхбаяр	Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
	Ж.Алтангэрэл	Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
	П.Баттүшиг	Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
	Л.Санжийжамц	Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
	И.Баттөгс	Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
	Д.Сайнхүү	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга
	Б.Чойжилсүрэн	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын Технологи, системийн хөгжүүлэлтийн хэлтсийн дарга
	Б.Түмэнбаяр	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын Дэд бүтэц, техникийн хяналтын хэлтсийн дарга
	О.Чинзориг	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын Цахим шилжилт зохицуулалтын хэлтсийн дарга
	Ц.Баттулга	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Засаглалын шинэчлэл, цахим хөгжил, төрийн үйлчилгээг боловсронгуй болгох асуудал хариуцсан мэргэжилтэн
	Г.Энхзул	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн ахлах мэргэжилтэн
	Ц.Батнавч	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын Төслийн хэрэгжилт, зохицуулалтын ахлах мэргэжилтэн
	Д.Пүрэвдорж	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын Технологи, системийн хөгжүүлэлтийн хэлтсийн систем хариуцсан ажилтан
Нарийн бичгийн дарга:	Б.Бат-Эрдэнэ	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын Төслийн хэрэгжилт, зохицуулалтын хэлтсийн дарга

Цахим хөгжил, харилцаа холбооны сайд,
Нийслэлийн Засаг даргаа бөгөөд Улаанбаатар
хотын захирагч нарын 2023 оны ..... дугаар
сарын ...-ны өдрийн ..... дугаар хамтарсан тушаал,
захирамжийн 2 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн "Цахим үндэстэн" болох зорилт, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 5.3-т "Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх", Шинэ сэргэлтийн бодлогын 4.1.2-т "Зам тээврийн хөдөлгөөний удирдлага хяналтын нэгдсэн ухаалаг систем бий болгоно", Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1-т "Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно", 4.3-т "Иргэдийн аюулгүй амар тайван байдлыг хангана", 6.3.11-т "Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем" төслийг бүрэн хэрэгжүүлнэ" гэж тус тус тусгагдсан байдаг.

Хоёр. Зорилго

Дүүргүүдийн цахим шилжилтийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, шаардагдах санхүүжилт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж "Цахим Дүүрэг" бодлогын зөвлөмж боловсруулж баталгаажуулах, хэрэгжилтийг хангах

Хоёр. Хугацаа, үе шат

2023 оны 08 дугаар сарын 15-наас 2023 оны 10 дугаар сарын 15-ны хооронд боловсруулж тус оны 03 дугаар улиралд багтаан Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна.

Гурав. Хамрах хүрээ

- Дүүргийн төрийн байгууллагууд
- Дүүргийн иргэд, тухайн дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагууд
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Бодлогын зөвлөмжийг боловсруулахад шаардлагатай судалгаа хийх, мэдээлэл цуглуулах
    a. Эрх зүйн орчин, бодлогын шинжилгээ хийх
    b. Олон улсын сайн туршлагыг судлах
    c. Тогтоосон судалгааны арга зүйн дагуу дүүргүүдийн цахим шилжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, дүгнэлт өгөх

   d. Дүүрэгт хэрэглэгдэж байгаа болон нэвтрүүлсэн цахим систем, поатформын ашиглалт, үр ашгийн талаар судлах, дүгнэлт гаргах
   e. Шаардлагатай бусад судалгаа хийх
2. Бодлогын зөвлөмжийн төсөл боловсруулах
   a. Судалгааны үр дүнд үндэслэн Цахим дүүргийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээ, дараалал,хүрэх үр дүнгийн талаар санал боловсруулах
   b. "Цахим дүүрэг" бодлогын зөвлөмжийн хүрээнд тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах төсвийн тооцоолол, ТХХТ-ийн талаар санал боловсруулах
3. Бодлогын зөвлөмжийн төслийг эцэслэн боловсруулж Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахад бэлтгэх
   a. Холбогдох талуудаар хэлэлцүүлэх, санал авах
   b. Шийдвэрийн төсөл бэлтгэх